

# Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

## Хувилбар -14

Сорилын зөв хариулт

1-B, 2-D, 3-A, 4-E, 5-A, 6-A, 7-A, 8-A, 9-A, 10-E, 11-E, 12-E, 13-E, 14-B, 15-C, 16-B, 17-E, 18-E, 19-A, 20-A, 21-C, 22-E, 23-A, 24-C, 25-C, 26-B, 27-D, 28-D, 29-C, 30-A, 31-E, 32-B, 33-A, 34-C, 35-A, 36-C, 37-A, 38-E, 39-B, 40-D, 41-D, 42-C, 43-A, 44-E, 45-D, 46-C, 47-C, 48-E, 49-C, 50-C, 51-A, 52-D, 53-D, 54-A, 55-B, 56-E, 57-B, 58-D, 59-A, 60-B, 61-C, 62-D, 63-D, 64-E, 65-A, 66-A, 67-C, 68-C, 69-C, 70-D, 71-E, 72-B, 73-B, 74-A, 75-A, 76-A, 77-C, 78-E, 79-A, 80-C, 81-A, 82-A, 83-A, 84-B, 85-A, 86-E, 87-B, 88-E, 89-C, 90-B, 91-C, 92-B, 93-A, 94-D, 95-C, 96-A, 97-A, 98-C, 99-E, 100-E,

1.Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2.Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)

1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3.Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (А.)

Зөв, Зөв, Буруу (В.)

Зөв, Буруу, Буруу (С.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Буруу тодорхойлолтыг сонгоно уу

А. Амьсгаадалт нь уушгины архаг бөглөрөлт өвчний үндсэн шинж мөн

В. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед амьсгаадалт зөвхөн ачааллын үед илэрнэ

С. Амьсгаадалт нь ихэнх өвчтөн эмнэлэгт хандах шалтгаан болдог

Д. Амьсгаадалтын улмаас өвчтөн албадмал байрлалд орж болно

Е. Амьсгалын замын халдвар амьсгаадалтыг сэдэрээж болно

/2./ Сүрьеэгийг микобактерээр хүн халдварлах үндсэн зам бол

А. Арьсаар

В. Хүнсээр

С. Ихсээр

Д. Агаар-дуслаар

Е. Салстаар

/3./ Дараахаас бусад өвчний үед гялтангийн болон хэвлийн хөндийд нэгэн зэрэг шингэн хурж болно

А. Шүүдэст плеврит

В. Элэгний цирроз

С. Зүрхний дутагдал

Д. Нефроз хам шинж

Е. Гипоальбуминеми

/4./ Уушгины тархмал сүрьеэгийн үед хамгийн элбэг гэмтэх эрхтэн бол

А. Яс

В. Бөөр

С. Гэдэс

Д. Дэлүү

Е. Серозон бүрхүүл

/5./ БЦЖ вакцин бол

- A. Сүрьеэгийн микобактерийн амьд сулруулсан өсгөвөр
  - B. Сүрьеэгийн микобактерийн амьдралын үйл явцад үүссэн бүтээгдэхүүн
  - C. Сүрьеэгийн микобактерийн үхсэн өсгөвөр
  - D. Шөлөн дээр ургуулсан сүрьеэгийн микобактерийн өсгөврийн фильтрат
  - E. Сүрьеэгийн савханцарын L-хэлбэр
- /6./ Уушгины архаг бөглөрөлт өвчний эмийн эмчилгээ:
- 1. Шинж тэмдгийг, ялангуяа амьсгаадалтыг багасгана
  - 2. Уушгины үйл ажиллагааны бууралтыг сааруулна
  - 3. Сэдрэлийн давтамж ба хүндийн зэргийг бууруулна
  - 4. Биеийн жингийн бууралтаас сэргийлнэ
  - 5. Амьсгалын булчингийн үйл ажиллагааг дэмжинэ
- /7./ 28 настай эмэгтэй. Ханиалгаж, 50 мл орчим цус гарсан. Юуны өмнө ямар эмгэгийн тухай бодож болох вэ?
- 1. Уушгины сүрьеэ
  - 2. Төрөлхийн артери-венийн холбоос
  - 3. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
  - 4. Уушгины хорт хавдар
  - 5. Муковисцидоз
- /8./ Уушгины архаг бөглөрөлт өвчний үед гуурсан хоолойн бөглөрөл үүсэх механизмыг нэрлэнэ үү:
- 1. Гуурсан хоолойн ханын үрэвсэл
  - 2. Цулцангийн ханын уян харимхай чанар буурах
  - 3. Гуурсан хоолой цэр, салсаар бөглөрөх
  - 4. Диффузлэх талбайн хэмжээ буурах
  - 5. Перибронхийн эдийн үрэвсэл
- /9./ Уушгины архаг бөглөрөлт өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү:
- 1. Тамхи
  - 2. Ажлын тоостой нөхцөл
  - 3. Агаарын бохирдол
  - 4. Амьсгалын замын цочмог халдвар
  - 5. Уушгины үрэвсэл
- /10./ Хоёр уушгины дунд, доод хэсгээр шажигнуур сонсогдох шалтгааныг нэрлэнэ үү:
- 1. Уушгины шалтгаан тодорхой бус завсрын эдийн үрэвсэл
  - 2. Уушгины завсрын эдийн вирусын шалтгаант үрэвсэл
  - 3. ARDS
  - 4. Гадаад шалтгаант харшлын альвеолит
  - 5. Уушгины цус алдалт
- /11./ БАӨ үед бөөр хамгаалах зорилгоор хэрэглэдэггүй эмийн бүлэг аль нь вэ?
- A. ACE ингибитор
  - B. AT-2 рецепторын блокатор
  - C. Антикоагулянт
  - D. Нон-дигидропиридин
  - E. Дигидропиридин
- /12./ Шээс цустах хам шинж хамгийн их илрэх өвчин
- A. Амилоидоз
  - B. Поликистоз
  - C. Архаг пиелонефрит
  - D. Архаг гломерулонефрит
  - E. Бөөрний сүрьеэ
- /13./ Хоногийн шээсний хэмжээ 100 мл-ээс багасахыг юу гэж нэрлэх вэ ?
- A. Полиури
  - B. Никтири
  - C. Поллакури
  - D. Дизури
  - E. Анури

- /14./ Жирэмсний эрт үед пиелонефритын эмчилгээнд хэрэглэх эм
- A. Нитрофураны бүлэг
  - B. Пенициллины бүлэг
  - C. цефалоспорины бэлдмэлүүд
  - D. Сульфаниламид
  - E. Нитроксилины бүлэг
- /15./ Бөөрний архаг өвчний 3-р үед ТШХ яаж өөрчлөгдөх вэ?
- A. ТШХ бага зэрэг буурсан 60-89 мл/мин
  - B. ТШХ бага зэрэг буурсан 30-60 мл/мин
  - C. ТШХ буурсан 30-59 мл/мин
  - D. ТШХ буурсан 30-49 мл/мин
  - E. ТШХ маш их буурсан 15-29 мл/мин
- /16./ Бөөрний хурц дутагдлын эрт үеийн үндсэн шинж тэмдэг нь
1. Олигоанури
  2. Цилиндрури
  3. Азотеми
  4. Хаван
  5. Гематури
- /17./ Бөөрний ангиографи хийх заалт нэрлэнэ үү?
1. Бөөрний судасны гаралтай АДИ
  2. Бөөрний вений бүлэн
  3. Донорын бөөрийг мэс заслын өмнө шинжлэх
  4. Суулгасан бөөрний артерт эмгэг үүссэн эсэх .
  5. Бөөрний хавдар
- /18./ БАӨ-ий 1-2р үе шатанд лабораторын шинжилгээгээр хянах үзүүлэлт
1. Шээсний хүчил
  2. Креатинин
  3. Электролит
  4. Өлөн үеийн сахар, липид
  5. ТШХ
- /19./ Бөөрний архаг дутагдлыг ямар үе шатанд хуваадаг вэ ?
1. Ээнэгшлийн үе
  2. Ээнэгшлээ алдах үе
  3. Уремийн үе
  4. Шалтгаан хүчин зүйлийн үе
  5. Олигоанурийн үе
- /20./ Түүдгэнцэрийн шүүлтийн үйл ажиллагаанд оролцдаг бүтцүүдийг нэрлэнэ үү?
1. Подоцит эс
  2. Суурин мембран
  3. Эндотель эс
  4. Мезангийн эс
  5. Боуман-Шумлянскийн капсул
- /21./ Архаг гломерулонефритын эмнэлзүйн аль ч хэлбэрийн үед бөөрний түүдгэнцэрт дархлалын үрэвсэл явагдана. Тийм ч учраас эмчилгээнд үрэвслийн эсрэг үйлдэлтэй сонгон антибиотик хэрэглэнэ.
- /22./ Архаг гломерулонефритын цусны даралт ихдэх хэлбэрийн үед преднизолон эмчилгээг, даралт буулгах эмтэй хослуулах нь үр дүнтэй. Учир нь преднизолон нь нянгийн гаралтай үрэвслийг дарахаас гадна, цусны даралтын бууралтыг дэмжинэ.
- /23./ Хеликобактериас ялгардаг ямар фермент эсийн хоорондын холбоог тасалж, нягтралыг бууруулан салслаг бүрхүүлийг нимгэрүүлдэг вэ?
- A. Протеаза
  - B. Уреаза
  - C. Цитотоксин

- D. Цитохромоксидаза  
E. Пепсин
- /24./ Гэдэсний нянгийн бичил орчин өөрчлөгдөхөд дээрх шинж тэмдгүүдээс аль нь илүүц вэ?  
A. Гэдэс дүүрч цанхайх  
B. Аманд гашуун амтагдах  
C. Өмхий үнэртэй унгах  
D. Гэдэс хуржигнан дугарах  
E. Өтгөн хатах
- /25./ Урсофалькийн үйлчилгээг нэрлэнэ үү.  
A. Цөсний гэрийн үрэвсэл намжаах  
B. Цөсний чулуу буталж жижиглэх  
C. Цөсний коллоид чанарыг сайжруулж, чулуу хайлуулах  
D. Цөс ялгаралтыг сайжруулах  
E. Цөс хөөлтийг сайжруулах
- /26./ Архины бус шалтгаант элэгний өөхжилтийн морфологийн шалгуур үзүүлэлт юу вэ.  
A. Элэгний эсийн өөхөн дистрофи тусдаа байх  
B. Элэгний эсийн өөхөн дистрофи нь үхжил, лимфогистиоцитарны нэвчдэс  
C. Дээрх хоеулаа
- /27./ Энтеритийн эмнэл зүйн явцаар нь ангилахад аль ангилал нь илүүц вэ?  
A. Дунд  
B. Хүнд  
C. Хөнгөн  
D. Хүндэвтэр  
E. Аль нь ч биш
- /28./ Бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн үед .....хэрэглэнэ.  
1. Фталазол  
2. Сульгин  
3. Трихопол  
4. Сульфасалазин  
5. Фуросолидон
- /29./ Эмийн шалтгаант гастритын үед хэрэглэх эмийг сонгоно уу?/  
1. Вентер  
2. Мизопростол  
3. Церукал  
4. Лансопразол  
5. Амоксициллин
- /30./ Улаан хоолойн агчил өвчний үед дурангаар ботулины хор тарих эмчилгээний заалтыг сонгоно уу?  
1. Манометрийн шинжилгээний шалгуураар онош тавихад хангалтгүй үед  
2. Эзофагомиотомии хийгээд үр дүнгүй үед  
3. Баритай гэрлийн шинжилгээнд шинж тэмдэг тогтвортой үед  
4. Улаан хоолойг сэлбээд үр дүнгүй үед  
5. Улаан хоолой хавдар
- /31./ Архаг холецистит үүсэхэд ямар хүчин зүйлс нөлөөлөх вэ?  
1. Цөсний зогсонгишил  
2. Цочмог холециститээр өвдсөн  
3. Хэвлийн хөндийн бусад үрэвсэлт өвчний үед  
4. Гэдэсний дисбактериоз  
5. Тогтмол хооллохгүй байх
- /32./ Шархлаа үүсэхэд нөлөөлөх удамшилын эрсдэл хүчин зүйлийг нэрлэнэ үү?  
1. OI бүлгийн цус  
2. Доминант хэлбэрээр удамших  
3. Альфа1-антитрипсиний дутагдал  
4. Рецессив хэлбэрээр удамших  
5. HLA-25, B2, BW25 эсрэгтөрөгч

/33./ Уиплийн өвчин нь нян устгах чадвар алдагдах, Т эсийн дархлаа болон макрофагийн эмзэгшилтэй холбоотой нарийн гэдэсний системийн өвчин юм. Эрэгтэйчүүдэд 5 дахин илүү тохиолдоно.

/34./ Одинофаги нь улаан хоолойн салстын урагдал, гэмтэл, эмийн болон вирусын шалтгаант үрэвсэл, мөөгөнцрийн гаралтай үрэвслийн үед тод ажиглагдана. Учир нь улаан хоолойн архаг үрэвслийн эмнэл зүйн гол шинж юм.

/35./ Гипокортицизмын эмнэл зүйн шинж

- A. Биеийн жин буурах
- B. Булчингийн тонус ихсэх
- C. Нимгэн цайвар язрал
- D. Цагаан шаргал царай
- E. Полименоррей

/36./ Инсулин бол

- A. Нүүрс ус
- B. Өөх тос
- C. Уураг
- D. Фермент
- E. Бүгд буруу

/37./ Тархмал хордлогот бахуугийн үед илэрдэг хоол боловсруулах замын талаас илрэх өөрчлөлтийг нэрлэнэ үү

- A. гүйлгэх
- B. хоолны дуршил буурах
- C. хоолны шингэц муудах
- D. өтгөн хатах
- E. бөөлжих

/38./ Чихрийн шижин хэвшинж 1-ийн эмнэлзүйн онцлог юу вэ?

- A. Өвчин анх илрэх нас 35-аас дээш
- B. Хамгийн элбэг тохиолдох нас 60-70
- C. Өвчний эхлэл аажим
- D. Кетозацидоз үүсэх нь ховор
- E. Биеийн жин хэвийн ба туранхай

/39./ Гипогликемийн байдлын үед хурдаг шингэдэг нүүрс устай хүнсийг гипогликемийн шинжүүд бүрэн арилтал хэдэн минутын зайтай хэрэглэх вэ?

- A. 5-10 минут
- B. 10-15 минут
- C. 15-20 минут
- D. 20-25 минут
- E. 25-30 минут

/40./ ЧШ-гийн нефропатийг эрт оношлох лабораторийн шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?

- 1. Кали ихсэх
- 2. Креатинин ихсэх
- 3. Түүдгэнцрийн фильтрацийн хурд багасах
- 4. Микроальбуминури
- 5. Протейнури

/41./ ЧШ хэвшинж 2-ийн эмгэг жам

- 1.  $\beta$  эсийн мембран вирусээр гэмтэж, нөхөн төлжилт буурна
- 2.  $\beta$  эсийн деструкц
- 3.  $\beta$  эсийн мембраны антиген шинж өөрчлөгдөнө
- 4. Инсулины рецепторын тоо цөөрнө
- 5.  $\beta$  эсийн тоо цөөрнө

/42./ Гипотиреоз бүхий өвчтөний 80 орчим хувьд гар хөл бадайрах шинж илэрдэг. Учир нь гипотиреозын үед мононейропати тохиолддоггүй.

/43./ 50 настай эрэгтэй, 20 –оод хоногийн өмнөөс анх удаа зүрхээр өвдсөн, өвдөлт нь сэтгэл санааны болон биений хүчний ачаалалтай холбоотой гэсэн өгүүлэмжтэй. Өвдөлтийн хүч хүчтэй бус, биеийн хүчний ачаалаа зогсоож, тайвшрахаар өвдөлт намддаг гэнэ. Тохиолдлоор хийсэн ЭКГ-т ST сегментийн ба Т шүдний өөрчлөлт илрээгүй. Та ямар хэлбэрийн стенокарди гэж таамаглаж байна вэ?

- A. Анхдагчаар үүссэн , ачаалалын үеийн стенокарди
- B. Ачаалалын үеийн тогтвортой стенокарди
- C. Гэнэт үүссэн тайван үеийн стенокарди
- D. Даамжрах явцтай стенокарди
- E. Тайван үеийн стенокарди

/44./ Аль нь миокардын үхжлийг илэрхийлдэг ЗЦБ-ийн шинж тэмдэг вэ?

- A. ST сегмент голч тэнхлэгээс доошлох
- B. ST сегмент голч тэнхлэгээс дээш өргөгдөх
- C. QRS иж бүрдэл өргөсөх
- D. Хуучин эмгэг шүд
- E. Шинээр үүссэн эмгэг Q шүд

/45./ Зүрхний дутагдлыг эрт илрүүлэх зорилгоор ямар шинжилгээг хийвэл илүү үр дүнтэй вэ?

- A. Зүрхний хэт авиан шинжилгээ
- B. Зүрхний ачаалалтай сорил
- C. Тропонин
- D. Натри ялгаруулагч пептид
- E. Зүрхний сцинтиграфи

/46./ Зүрхний шигдээстэй өвчтөнд яаралтай тусламж үзүүлэхдээ аспириныг ямар тунгаар өгөх вэ?

- A. 75-81мг
- B. 100 мг
- C. 162-325мг
- D. 500 мг
- E. 162-500мг

/47./ Зүрх судасны эрсдэлтэй нас, хүйсний байдлыг тодорхойлно уу?

- A. Эрэгтэй >40, эмэгтэй >50
- B. Эрэгтэй >45, эмэгтэй >50
- C. Эрэгтэй >45, эмэгтэй >55
- D. Эрэгтэй >50, эмэгтэй >60
- E. Эрэгтэй >55, эмэгтэй >65

/48./ Зүрхний архаг дутагдалд хамаарах зөв хариултыг сонгоно уу?

1. Тархалт нь нас ахих тутам ихэсдэг
2. Систолын дутагдал нь илүү тохиолддог
3. Хөгжиж буй орнуудад зүрхний олдмол гажиг нь гол шалтгаануудын нэг болдог
4. Зүрх судасны гаралтай нас баралтын гол шалтгааны нэг мөн
5. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үндсэн шалтгааны нэг

/49./ Дигоксин нь...

1. Синусын хэмнэлттэй митрал хавхлагын нарийслын үед хэрэглэх заалттай
2. зүрхний дутагдлын зовиурыг багасгана
3. Зүрхний дутагдлын үеийн амьдрах чадварыг сайжруулна
4. Зүрхний хориг үүсгэнэ
5. Тахиаритми үүсгэнэ

/50./ Артерийн гипертензитэй өвчтөн зүрхний архаг дутагдалтай тохиолдолд даралт бууруулах эмийн бэлдмэлээс алийг нь сонговол илүү үр дүнтэй вэ?

1. Атенолол
2. Каптоприл

3. Амлодипин
4. Гипотиазид
5. Празоцин

/51./ Миокардитын үед багажийн болон лабораторийн шинжилгээнд ямар өөрчлөлт гардаг вэ?

1. Рентгенд зүрх томрох
2. Сийвэнд СРБ эерэг гарах
3. Сийвэнд ГОТ, ЛДГ ихсэх
4. Сийвэнд СРБ сөрөг гарах
5. Лейкоцитоз

/52./ Варфариныг зүрхний шигдээсийн үед ямар үзүүлэлтээр хянаж хэрэглэдэг вэ?

1. Тромбины хугацаа
2. а РТТ
3. Протромбины хугацаа
4. INR
5. Фибриноген

/53./ Артерийн гипертензийн баруун ховдлын томрол үүсдэг. Баруун ховдлын томролыг ЗЦБ-р оношлодог.

/54./ Гемофили өвчний оношийг батлахын тулд ямар шинжилгээг заавал хийх вэ?

- A. Цусанд VIII, IX факторыг үзүүлэх
- B. Тархины КТГ
- C. Хэвлийн ЭХО
- D. Цус гоожих хугацаа үзэх
- E. Д-димерын шинжилгээ

/55./ Архаг миелолойкозын ид үед цитогенетикийн шинжилгээний хариу гараагүй үед эмчилгээнд аль эмийн бэлдмэлийг хэрэглэх нь зохистой вэ?

- A. Цитозар
- B. Гидроксиуреа
- C. Рубомицин
- D. Гливек
- E. Флудара

/56./ Тотемагийн төмрийн агууламжийг сонгоно уу?

- A. 10мг
- B. 162мг
- C. 150мг
- D. 100мг
- E. 50мг

/57./ Аутоиммун тромбоцитопенитэй өвчтөнд дэлүү авах заалт:

- A. Иммунодепрессант эмүүд хэрэглэсэн ч үр дүнгүй байгаа тохиолдолд
- B. Гормон эмчилгээнд үр дүнгүй, жилд 2-3 удаа сэдрэл өгч байгаа тохиолдолд
- C.  $\alpha$ 2-интерферон эмчилгээнд үр дүнгүй байгаа тохиолдолд
- D. Полихими эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд
- E. Монохими эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд

/58./ Экхимоз гэдэг нь....

- A. 5 см болон түүнээс дээш диаметр хэмжээтэй, арьсны түвшингээс овойгоогүй
- B. Хэмжээний хувьд үзэгний үзүүр төдий олон тооны цусархаг тууралт
- C. Дотор эрхтний гаралтай цус алдалт
- D. 5 см хүртэлх диаметр хэмжээтэй, ихэвчлэн судас тойрон гардаг тууралт
- E. Цустай ханиах, цустай цэр гарах зэрэг амьсгалын эрхтэн системээс илрэх өөрчлөлт

/59./ Төмрийн бэлдмэлийн гаж нөлөөг ол?

1. Шүд харлах
2. Өтгөн хатах
3. Хэвлийгээр өвдөх

4. Төмрийн хурц хордлого
  5. Төмрийн архаг хордлого
- /60./ Хүйтний аутоиммуны цус задралын цус багадалтын шалтгаануудыг заа
1. Микоплазмын халдвар
  2. Тэмбүү
  3. Халдварт мононуклеоз
  4. Архаг миелолейкеми
  5. Түгмэл чонон яр
- /61./ Ургийн толгой аарцгийн хөндийд гарах хэсэгт байхад суман заадас ямар хэмжээнд байх вэ?
- A. Хөндлөн
  - B. Баруун ташуу
  - C. Шулуун
  - D. Зүүн ташуу
  - E. Тодорхой биш
- /62./ Хэвийн явцтай жирэмсэн үед биеийн жин хэдэн кг нэмэгдэх вэ?
- A. 8 кг
  - B. 6 кг
  - C. 4 кг
  - D. 10-12 кг
  - E. 15-16 кг
- /63./ Жирэмсний эрт хугацаанд аяндаа зулбах үндсэн шалтгааныг нэрлэнэ үү:
- A. Цусны бүлгийн үл тохироо
  - B. Хүнд юм өргөх
  - C. Умайд соривтой байх
  - D. Хромосомын гажиг
  - E. Умайн хүзүүний дутмагшил
- /64./ Үйл ажиллагааны оношилгоонд хамаарах шинжилгээг нэрлэнэ үү:
1. Цусанд бэлгийн даавар тодорхойлох
  2. Хүүхэн харааны шинж
  3. Оймын навчны шинж
  4. Кольпоцитологи
  5. Умайгаас хусам авч шинжлэх
- /65./ Хожуу хордлогын Цангмейстерын үндсэн шинж:
1. Хаван
  2. Шээсээр уураг ялгарах
  3. Даралт ихсэх
  4. Таталт
  5. Нойргүйдэл
- /66./ Жирэмсний эрт үеийн хордлогэмнэл зүйн шинж?
1. Огиулж бөөлжих
  2. Хоолонд дургүй болох
  3. Үнэрлэх, амтлах мэдрэхүй өөрчлөгдөх
  4. Даралт ихсэх
  5. Хавагнах
- /67./ Гол судас – уушигны артерийн хооронд үүссэн цоорхойн оношлогооны чухал арга
- A. Зүрх сэтгүүрдэх
  - B. Баруун венрикулографи
  - C. Аортографи
  - D. Зүүн венрикулографи
  - E. Флевографи
- /68./ Цээжний хөндийн битүү гэмтлийн үед уушгийг гэмтээсэн шинж тэмдэг нь:
- A. Өвдөлт
  - B. Амьсгалах ажиллагаа алдагдах
  - C. Гэмтсэн талд амьсгалын чимээ сонсогдохгүй байх



- D. Гэмтсэн талд хуурай хэрчигнүүр сонсогдох  
E. Гэмтсэн талд нойтон хэрчигнүүр сонсогдох
- /69./ Бүдүүн гэдэсний өвөрмөц бус шархлаат үрэвслийн үед гэрлийн шинжилгээнд шинж нь илрэх вэ?
- A. Гэдэсний нарийсалт
  - B. Гэдэсний пассаж алдагдах
  - C. Салстын рельеф тэнэгэр болох
  - D. Гэдэсний гаустр алдагдах
  - E. Хэлбэр дүрс нь өөрчлөгдөх
- /70./ Гуурсан хоолойн багтраа, гипервентиляци, анафилаксийн шок зэргийн үед бүгдэд нь адилхан илрэх ямар шинж байна вэ?
- A. Бүгдэд нь амилуулах амьсгалуулалт хийх заалттай
  - B. Зөвхөн хүүхдэд тохиолдоно
  - C. Бүгд амь тэнссэн байдлын илрэл
  - D. Бүгдэд нь амьсгалын дутагдлын шинж илэрнэ
  - E. Бүгдэд нь артерийн даралт нь буурна
- /71./ Осолдсон хүнийг амь тэнссэн байдалд орсон эсэхийг үнэлэх үзүүлэлтэнд хамаарахыг нь тэмдэглэнэ үү?
- 1. Осолдогчтой харилцаж, дуудах
  - 2. Амьсгалын замыг чөлөөлөх
  - 3. Амьсгалалтыг чагнах
  - 4. Цус алдаж байгаа эсэхийг шалгах
  - 5. Судасны лугшилтыг тэмтэрч үзэх
- /72./ Хөхний хавдартай өвчтөний үнхэлцгэнд шингэн хуримтлагдсан ба амьсгаадаж, амьсгал давчидаж, арьс нь хөхөрч, албадмал байдалтай сууж байвал түүний амьсгаадалтын шалтгааныг яаж эмчлэх вэ?
- A. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
  - B. Үнхэлцгэнд хатгалт хийж шингэнийг соруулах
  - C. Антибиотик
  - D. Хими, туяа эмчилгээ
  - E. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ
- /73./ Трамадол нь эмийн ямар бүлэгт хамрах вэ?
- 1. Опиоид эмийн бүлэгт хамрана.
  - 2. Стероид бус өвдөлт намдаах эм.
  - 3. Өвдөлт намдаах 2-р шатанд хэрэглэх опиоид эмийн бүлэгт хамрана
  - 4. Хүчтэй өвдөлт намдаах опиоид эмийн бүлэгт хамрана.
  - 5. Өвдөлт намдаах туслах эмийн бүлэгт хамрана.
- /74./ Хэлээ амнаас гүйцэд гарахгүй, хахаж цацна. Хэлний булчин хатингир.
- A. Бульбар саа
  - B. Хуурамч бульбар саа
  - C. Хэлний дорхи мэдрэлийн саа
  - D. Хэл залгиурын мэдрэлийн ян
  - E. Зажлуурын булчингийн саа
- /75./ Залуу эмэгтэй ханиад хүрсний дараа 2 нүд 7 хоногийн зайтай сохорсон. Энэ тохиолдолд онош тодруулах зайлшгүй шинжилгээ:
- 1. VEP(Visual Evoked Potential)
  - 2. Тархины КТ
  - 3. Нүдний уг
  - 4. ЭЭГ
  - 5. ДСГ
- /76./ Уушгины гэрлийн шинжилгээнд эмгэг сүүдрийн тодрол юуг заадаг вэ ?
- A. Өөрчлөлтийн идэвхийг
  - B. Өөрчлөлтийн бүтэцийг
  - C. Өөрчлөлтийн шалтгааныг
  - D. Өөрчлөлтийн байрлалыг

- Е. Дээрхи бүгд
- /77./ Идэвхитэй сүрьеэ, уушгины хорт хавдартай хавсарсан тохиолдолд туяа эмчилгээ, гормон эмчилгээ, цитостатик бэлдэмлээр эмчлэх үү?
- А. Сүрьеэ даамжирч болох тул хэрэглэхгүй
  - В. Ховор тохиолдолд хэрэглэнэ
  - С. Сүрьеэгийн эмчилгээтэй хавсарч хэрэглэнэ
  - Д. Хордлого тайлах эмчилгээтэй хавсарч хэрэглэнэ
  - Е. Дээрхи бүгд
- /78./ Цэрний түрхэцийн шинжилгээний давуутай талуудыг тоочно уу?
1. Хялбар
  2. Богино хугацаанд хариу гарна
  3. Халдвартай хэлбэрийн сүрьеэг оношилно
  4. Оношийг найдвартай батална.
  5. Хямд өртөгтэй
- /79./ Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг явуулах чиглэлүүдийг нэрлэнэ үү?
1. Шууд хяналттай эмчлэх
  2. Үр дүнгийн хяналт хийх
  3. Гаж урвалын хяналт хийх
  4. Биеийн жингийн хяналт
  5. Цусны ерөнхий шинжилгээ хийх
- /80./ Цочмог А гепатитын үед шарлалтын үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?
- А. 1-7 хоног
  - В. 2-14 хоног
  - С. 2-3 долоо хоног
  - Д. 1-2 сар
  - Е. 1-3 сар
- /81./ Салхин цэцэг өвчний халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?
- А. Агаар дуслаар
  - В. Цус
  - С. Хоол хүнс
  - Д. Бэлгийн зам
  - Е. Парентераль зам
- /82./ Гепатитын В вирусийн халдварыг дамжуулж болох хүчин зүйлийг тэмдэглэ.
1. Цус
  2. Зүү тариур
  3. Үрийн шингэн
  4. Бохир гар
  5. Ахуйн хавьтал
- /83./ Татрангийн таталтын онцлогийг тэмдэглэ
1. Өвдөлттэй
  2. Их хүчтэй
  3. Татах үедээ ухаан алдахгүй
  4. Богино хугацааны
  5. Сул
- /84./ Харааны мэдрүүлийн хаван удтал үргэлжилбэл ямар өвчин болж хүндэрдэг вэ?
- А. Харааны мэдрүүлийн хавдар
  - В. Харааны мэдрүүлийн хатингаршил
  - С. Харааны мэдрүүлийн үрэвсэл
  - Д. Харааны мэдрүүлийн шинэ судасжилт
  - Е. Шар толбоны дегенерац
- /85./ Хам хяларыг саа хялараас ямар шинжээр ялгах вэ?
1. Нүдний хөдөлгөөн бүх чиглэлд чөлөөтэй
  2. Хяларын анхдагч өнцөг хоёрдогч өнцөгтэй тэнцүү
  3. Юм давхарлаж харагдахгүй
  4. Хос хараа хадгалагдсан байна

5. Юмыг оноож харах үйл идэвхтэй
- /86./ Миопийн давшлын эсрэг ямар эмчилгээ хийгдэх вэ?
1. Атропин сульфат
  2. Витамин эмчилгээ
  3. Кальцийн төрлийн эмүүд
  4. Харааны ачааллыг багасгах
  5. Хүнд хүчир ажлаас чөлөөлөх
- /87./ Орофарингоскопи хийхдээ хэл дарагчийг хаана байрлуулах вэ?

- A. Хэлний уг дээр
  - B. Хэлний өмнөд 2/3 хэсэгт
  - C. Хэлний үзүүрт
  - D. Хэлний өмнөд 1/3 хэсэгт
  - E. Хэлийг дарахгүйгээр ам залгиурыг шинжилсэн ч болно.
- /88./ Дунд чихний цочмог үрэвслийн шалтгаан болдог үүсгэгчдийг нэрлэнэ үү
1. Streptococcus pneumonia
  2. Moraxella catarrhalis
  3. Haemophilus influenza
  4. Staphylococcus aureus
  5. Pseudomonas aeroginesa

/89./ Хамар, нүүрний хавсарсан гэмтлийн үед тархи доргих, тархинд цус харвах, ухархайд буглаа үүсэх, нүд хараа алдагдах зэрэг хүндрэл тохиолдож болно(1). Эдгээр нь хамар засах хагалгааны дараа аяндаа эдгэрнэ (2).

/90./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөг рүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьегийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар өвчин байх магадлал илүү өндөр байна вэ?

- A. Хэрх өвчин
  - B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
  - C. Остеоартрит
  - D. Тулай
  - E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр
- /91./ Настан яагаад даавуун оймс, хөлөнд таарсан арьс, ширэн буюу эсгий гутал өмсөж байх ёстой вэ?
1. Настан их хөлрөмтгий болж, шивэртдэг тул
  2. Далд чихрийн шижинтэй настан хөлөө даарах, халах, холгохыг мэдэрдэггүй, том шарх үүссэний дараа түүнийг эмчлэх боломжгүй тул.
  3. Настангийн хөл мөөгөнцөрдөх хандлагатай тул
  4. Далд чихрийн шижинтэй настанд хөлний макроангиопатийн хүндрэлээс сэргийлэхийн тулд
  5. Буянтай буурал үнэтэй зүйл хэрэглэх эрхтэй тул.

/92./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 90 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- A. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй
- B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн
- C. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- D. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа
- E. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг

/93./ Шээс задгайрлыг оношлохын тулд өрхийн эмч настанд ямар сорил хийж болох вэ?

1. Давсаг дүүрэн шээстэй зогсоогоод ханиахыг настангаас хүсэх ба ханиах үед шээс даруй гарч байвал хүчлэлийн шээс задгайрал гэж үзнэ

2. Шээс задгайрлыг илрүүлэх олон улсын асуумжийг хэрэглэж асуумж авна

3. Давсаг дүүрэн шээстэй зогсоогоод, ханиахыг настангаас хүсэх ба ханиах үед шээс хожуу гарч байвал давсагны булчин суларсантай холбоотой шээс задгайрал гэж үзнэ

4. Урографийн шинжилгээг тодруулагч бодис судсанд тарьсны дараа хийнэ.

5. Цистоскопийн шинжилгээ хийнэ

/94./ Үений хөдөлгөөн хязгаарлалтын Бенклэрийн ангилалын 3-аар үеийг заана уу.

А. Өдөр тутмын үйл ажиллагаа саадгүй, өөртөө үйлчлэх чавдар саадгүй.

В. Мэргэжил болон өөртөө үйлчлэх чадвар хэвийн боловч чөлөөт цагаар хичээллэх нь хязгаарлагдах.

С. Үений хөдөлгөөн хязгаарлагдсан эсвэл хөдөлгөөнгүй болох, өөртөө үйлчлэх чавдар маш муу.

Д. Мэргэжил болон чөлөөт цагаар хичээллэх нь хязгаарлагдах ба өөртөө үйлчлэх чавдар алдагдана.

Е. Бүх үйл ажиллагаа алдагдана.

/95./ Rheumatoid arthritis оношлогооны шалгууртыг нэрлэнэ үү.

1. Ясны хэлбэр алдагдана.

2. Жижиг үеүд үрэвсэнэ.

3. Арьсан дээр тууралт гарна.

4. Цусанд Ц урвалж уураг ихсэнэ.

5. Өглөөгүүр үений шажигналт илрэнэ.

/96./ Сүрьеэгийн үений үрэвслийн үед ихэвчлэн ямар үе гэмтэх вэ.

1. Түнх

2. Өвдөг

3. Нуруу

4. Тохой

5. Шагай

/97./ Тулайн цочмог артритын үед илрэх эмнэлзүйн шинжийг нэрлэнэ үү.

1. 85 хувь моноартрит илрэнэ

2. Маш хурдан улайж хавдана.

3. Целлюит үүснэ.

4. Эмнэлзүй нь шөнө болон үүрээр эрт үүснэ.

5. Өвдөлт ихсэнэ, үе орчмын дагуу халуун нэмэгдэнэ.

/98./ Эрхтэн тогтолцооны чонон хөрвөсийн цусны талаас илрэх өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү:

1. Тромбоцитоз  $>400.0 \times 10^2$  г/л

2. Лейкопени  $<4.0 \times 10^2$  г/л

3. Лейкоцитоз  $>11.00 \times 10^2$  г/л

4. Тромбоцитопени  $<100.0 \times 10^2$  г/л

5. Миелоцитоз

/99./ Барьцалдаат спондилитыг эмнэлзүйн хам шинжийг нэрлэнэ үү:

1. 3 сараас удаан хугацаанд бүсэлхий нуруугаар өвдөх

2. Скоберын сорил эерэг байх

3. Нүдний судаслаг бүрхүүлийн үрэвсэл байх

4. Цээжний займчих хөдөлгөөн багасах

5. "Wall stand" сорил эерэг байх

/100./ Үений мөгөөрс нь цус тунгалагийн судсаар баялаг байдаг учир нөхөн төлжилт хамгийн сайн байдаг.